



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ!

№91 (91) 2021.07.08

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ҮЙЛ ЯВДАЛ

Ж.БОЛДБААТАР: ЦЭРГИЙН ЭМЧ НАР ХЭРЭГТЭЙ ЦАГ ҮЕД ТЭРГҮҮН ШУГАМД ЗОГСОЖ, ҮҮРГЭЭ АМЖИЛТАЙ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, БХЯ-ны ХШУДАГ-ын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын албаны дарга, хурандаа Т.Мөнхбаяр, ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн, хурандаа Д.Содномдаржаа нарын ажлын хэсэг өчигдөр Цэргийн төв эмнэлэгт ажиллалаа.

Тэд тус эмнэлгийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай танилцахаас гадна, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн үйл ажиллагаа, ёс зүйн чиглэлээр хийж байгаа ажилтай танилцав. Түүнчлэн Цэргийн төв эмнэлгийн ногоон бүсийн үйл ажиллагаа, эмнэлгийн үйл ажиллагааны тайлантай танилцаж цаг үеийн мэдээлэл авлаа. Тус тайланд "Ковид-19" цар тахлын өнөөгийн нөхцөл байдал, ногоон болон улаан бүсэд ажиллаж байгаа эмч, ажилтан алба хаагчдын судалгаа, дархлаажуулалт, эм тариа, эмчилгээнд хэрэглэгдэх бусад

зүйлсийн нөөц, цалин урамшууллын зэргийн талаар мэдээллийг багтаажээ. Үүний дараа тэд ногоон бүсэд ажиллаж байгаа алба, тасгийн дарга нараас дээших албан тушаалтнуудтай уулзалт хийлээ. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар "Цэргийн төв эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан алба хаагч бүр улс оронд тохиолдож байгаа хүнд цаг үед үүргээ амжилттай гүйцэтгэж байна. Тэд цэрэг хүний, эмч хүний тангарагтаа үнэнч байж тэргүүн шугамд ажиллаж байгаад нь талархаж байна" гэв. Ингээд тэрээр цааш нь үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайдын хүрээнд хийгдэж байгаа ажил, арга хэмжээний талаар танилцуулж, цаашид авч хэрэгжүүлбэл зохиох чиглэсэн үүргийг өглөө.

Тухайлбал, "Батлан хамгаалах Иргэний хяналт 1800-1144" тусгай дугаар ажиллах журмыг Төрийн нарийн бичгийн даргын 2021оны А/29 дүгээр тушаалаар баталж, энэхүү тусгай дугаараар БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал,



цэргийн нэгтгэл, анги, салбартай холбоотой аливаа мэдээллийг 24 цагийн турш хүлээн авч байна. Мөн Зэвсэгт хүчний ангиудын хяналтын камер болон дагалдах хэрэгслийн судалгаа, тооцоог үндэслэж, Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/80 дугаар тушаалын дагуу эхний ээлжид хугацаат цэргийн алба хаагчидтай нэгтгэл, ангиудын камержуулалтын ажлыг 2021 оны II улиралд багтаан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байгаа талаар болон Батлан хамгаалахын сайдын дэргэдэх "Иргэний зөвлөл"-ийн ажиллах журмыг Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар баталгаажуулж, Иргэний зөвлөлийн гишүүдийг томилоод байгаа зэрэг мэдээллүүдийг өглөө. Үүний дараа Цэргийн төв эмнэлгийн алба, тасгийн дарга нараас дээших ажилтан албан хаагчид хандан дараах чиглэсэн үүргийг өгөв. Үүнд, 1. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Батлан хамгаалахын сайдын 2015 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан

"Зэвсэгт хүчний анги, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах дүрэм"-ийн хэрэгжилтийг хангах;

2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх;

3. Байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх;

4. Төсөв санхүүгийн сахилга хариуцлага, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, дотоод аудиттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг судлах сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах;

5. Удирдах бүрэлдэхүүний ёс зүйн байдалд анхаарах, хяналт тавих зэргийг үргэжээд Батлан хамгаалахын сайдаас дэвшүүлээд байгаа "Хандлага өөрчилж Хариуцлага дээшлүүлэе" уриалгыг хүн бүхэн дор бүрнээ ажил, албандаа хэрэгжүүлэн ажиллахыг захилаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
30	12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
31	21

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
41	29

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.00	2.852.00
EUR	3.380.00	3.400.00
CNY	440.50	441.50
RUB	37.80	39.40
JPY	25.46	25.94
KRW	2.42	2.55

ЗУРХАЙ

Билгийн тооллын: 29,
2021.07.08
/ПҮРЭВ ГАРАГ/

ЗУНЫ ДҮНД ХӨХ МОРЬ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

Наран ургах, шингэх:

05.02-20.52

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Суудал:

Уул

Аргын тооллын: 29,
2021.07.08, Пүрэв гараг. Билгийн

тооллын: 29, Гөрөөсөн толгой

одтой, улаагчин могой өдөр.

Тухайн өдөр тахиа жилтнээ

аливаа үйлийг хийхэд зэрэг сайн

ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ

сөрөг муу нөлөөтэй тул элдэв

үйлд хянамгай хандаж, биеэ

энхрийлүүштэй. Эл өдөр найз

нөхдийг түшиж элдэв үйлийг

түргэн бүтээх, бүтээл туурвил

эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй

үйлийг эхлэх, бясалгал хийх,

доодсыг асран өглөг, хандив

өргөх, сан тавиулах, угаал

үйлдэх, газар лусын зан үйл хийх,

өр бараагуулах, гэр бүрэхэд

сайн. Ургаа мод таслах, газрын

ам нээх, сэтгэлд сэтгэй газар

очиход муу. Өдрийн сайн цаг нь

үхэр, луу, морь, хонь, нохой, гахай

болтой. Хол газар яваар одоосод

баруун хойш мөрөө гаргавал

зохистой. Үс шинээр үргээлгэх

буюу засуулахад тохиромжгүй.

Э.ДАВААЖАМЦ БАГАНУУР ДҮҮРГЭЭР ДАЙРАН ӨНГӨРЛӨӨ



Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Ховд аймгаас гарснаас хойш 36 дахь өдрийнхөө гүйлтийг хийж 1584 километр замыг туулан нийслэлийн Багануур дүүрэгт өчигдөр ирлээ. Түүнийг Багануур дүүрэгт хүрэлцэн ирэхэд Багануур дүүргийн ЭДТГ-ын Цэргийн штабын хамт олон, цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн хүлээн авлаа. Мөн энэ үеэр цагдаагийн байгууллагаас зохион

байгуулж буй хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх "Ирээдүйгээ хамгаалъя" аянд нэгдэж, хүүхэд бүхнийг эрсдэлээс хамгаалж, иргэн бүр хариуцлагатай байж бидний ирээдүй болсон бяцхан үрсээ хамгаалахыг уриаллаа. Ийнхүү түүнийг цааш үдэн гаргаж өгсөн бөгөөд хамгийн богино хугацаанд эх орны баруун хязгаараас зүүн хязгаар хүртэл гүйх эр зоригт, тэсвэр хатуужилтай ахлагчид амжилт хүсье.

ЗӨВ ЗҮЙЛД УРИАЛАН ДУУДЬЯ

Зэвсэгт хүчний 186 дугаар анги



Коронавируст халдварын цар тахал нэмэгдэж иргэдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулж байгаа энэ үед Орхон аймгийн Засаг даргын гаргасан "Заавал мөрдөх 5 зарчим"-ыг дагаж хэрэгжүүлж байна.

Энэ ажлын хүрээнд тэд халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, айл өрх, албан байгууллага бүрд санамжуудыг тараан байрлуулж, уриалгыг дэвшүүлэн ажиллаа.

Хошууч Т.ЗАЯАНДАРЬ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 130.452 +1198	ЭДГЭРСЭН 92,299 +2582	НАС БАРСАН 646 +7
-----------------------------------	--------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 3601 +60	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 340 +21	ЭДГЭРСЭН 3199 +35
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 185,821,811
Эдгэрсэн Нийт: 170,077,520
Нас барсан Нийт: 4,017,198



ҮЙЛ ЯВДАЛ

АЙМГУУД ХӨЛ ХОРИО ТОГТООХДОО УЛСЫН ОНЦГОЙ КОМИССТОЙ ЗӨВШИЛЦӨНӨ

Засгийн газрын ээлжит хуралдаан өчигдөр боллоо. Энэ удаагийн хуралдаанаар цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа ажлын талаарх мэдээллийг сонсов. Өнөөдрийн байдлаар 20 аймагт халдварын 30,299 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд эмнэлэг болон тусгаарлан эмчлэх байранд 7,476 иргэн хэвтэн эмчлүүлж байна. Биеийн байдал нь хөнгөн 6,402, хүндэвтэр 869, хүнд 170, нэн хүнд 35 иргэн байна. Орон нутагт халдварын тархалт, эмнэлгийн ачаалал нэмэгдсэнтэй холбогдуулан 18 аймгийн 196 сум, зургаан тосгонд хязгаарлалтын дэглэм тогтоосон. Эдгээрээс 13 аймгийн 101 сумын хөл хорио наадмаас өмнө цуцлагдах юм. Засгийн газрын шийдвэрээр 2021 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс 19-ний өдрийг хүртэл өс хоног амарна. Түүнчлэн зуны улиралтай холбогдуулан иргэдийн хөдөө,

Эрдэнэ чөлөөт бүсийг энэ зун нээж байнгын ажиллагаанд оруулах үүрэг өгөв. Эрхзүй, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлснээр:
-Экспорт, импорт нэмэгдэнэ;
-Үйлдвэрүүд хөгжинэ;
-Худалдаа, үйлчилгээний шинэ салбарууд бий болно;
-Шууд ажлын байр бий болно;
-Бүтээн байгуулалт нэмэгдэнэ;
-Аялал жуулчлал хөгжинэ;
-Тэргүүний техник, технологи нутагшина;
-Транзит тээвэр, логистик нэмэгдэнэ;
-Худалдааг хөнгөвчилнө;
-Бус нутгийн хөгжил эрчимжинэ гэж үзэж байна. Тухайлбал 2026 он гэхэд хөрөнгө оруулагчийн тоо 70-д хүрч 9,400 ажлын байр бий болох юм. 2034 он гэхэд экспортын бүтээгдэхүүн

нэвтрүүлээд байна. Медаль хүртсэн тамирчдад урамшуулал олгоно
"Тамирчин", дасгалжуулагчдад 2021 онд олгох мөнгөн урамшуулал, шагналын тухай" тогтоолын төслийг баталлаа. Энэ дагуу Олимп, паралимп, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс спортын есөн төрлөөр медаль хүртсэн нэр бүхий 58 тамирчинд сар бүр нийт 132 сая төгрөг, Боксын залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн болон Шатрын их мастерын болзол хангасан тамирчид, дасгалжуулагч нарт нэг удаа нийт 104 сая төгрөг олгоно. 2013-2020 онд Олимп, паралимп, наадмаас гурван алт, долоон мөнгө, 13 хүрэл медаль, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 15 алт, 22 мөнгө, 42 хүрэл медаль хүртсэн 58 тамирчинд 11 тэрбум гаруй



орон нутаг руу чиглэх хөдөлгөөн эрс нэмэгдэх төлөвтэй байна. Үүнтэй холбогдуулан:
-Импорт, экспортын гол боомтуудтай аймаг, орон нутагт хатуу хөл хорио хэвээр үргэлжилнэ. Боомтууд хэвийн үйл ажиллагаанд шилжих хүртэл хөдөлгөөнийг хязгаарлах;
-Аймгууд бие даан хязгаарлалт тогтоохгүй. Зөвхөн Улсын онцгой комисстой зөвшилцөж хязгаарлалт, хөл хорио тогтоох;
-Иргэд орон нутагт зорчихдоо айлаар орохгүй, суурин газрын хөдөлгөөнд оролцохгүй, зөвхөн жуулчны бааз, амралтын газраар үйлчлүүлэх;
-Бүрэн вакцин хамрагдсан эсвэл өвчлөөд эдгэрсэн хүмүүс орон нутаг руу зорчих боломжтой, гэр бүлээрээ явж байгаа бол таваас дээш насны нэг хүүхдээс түргэвчилсэн шинжилгээ авах;
-Үйлчилгээний байгууллагуудыг ээлж дараатай нээх эсэхийг Нийслэлийн онцгой комисс урьдын адил хариуцах, ингэхдээ 22.00 цагаас хойш ажиллуулахгүй байх зэрэгт анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Ерөнхий сайд чиглэл болгов.

гурав дахин нэмэгдэх бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт 2,9 тэрбум ам.долларт хүрч 18 мянган ажлын байр бий болох тооцоо гарчээ.

төгрөгийн мөнгөн урамшуулал, 2015-2020 онд 4,411 тамирчин, дасгалжуулагчид долоон тэрбум гаруй төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал олгожээ. Мөн Олимп, паралимп, дифлимп, тусгай олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнээс алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн хөгжлийн бэрхшээлтэй 43 тамирчинд урамшуулал олгоход шаардагдах 230 орчим сая төгрөгийг төсвийн багцаасаа гаргахыг сайд А.Ариунзаяад зөвшөөрөв. Мөнгөн шагнал, урамшуулал нь тамирчид, дасгалжуулагчдын нийгмийн баталгааг хангах, спортоор хичээллэх, амжилт гаргахад нь эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой юм.

ТОВЧ МЭДЭЭ

-Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлэхээр болов.
-"Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам", "Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам"-ыг шинэчлэн батлав.
-Цар тахлын үед хөл хорионы шатлал харгалзалгүй ургац хуралтын бэлтгэлийг эртнээс сайтар хангахыг сайд З.Мэндсайханд даалгав. Одоогоор 414 мянган га-д ур тариа, үүнээс 384 мянган га-д улаанбуудай, 16 орчим мянган га-д төмс, 8.4 мянган га-д хүнсний ногоо, 68 мянган га-д тосны ургамал, 42 орчим мянган га-д тэжээлийн ургамал, 4.7 мянган га-д жимс, жимсгэнэ тариалаад байна.

"Токио-2020" олимпод оролцох "Алдар" спорт хорооны тамирчдыг танилцуулж байна

МОНГОЛЫН БУУДЛАГЫН СПОРТЫН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН ТАМИРЧИН, ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ МАСТЕР АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААХҮҮ

Монгол Улсын үндэсний шигшээ баг, Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны тамирчин, Алтан гадас одонт, Олон улсын хэмжээний мастер ахлах ахлагч Энхтайван овогтой Даваахүү нь 1989 оны 6 дугаар сарын 12-нд Улаанбаатар хотын Налайх дүүрэгт төрсөн. Эхнэр, гурван хүүхдийн хамт амьдардаг.
2008 оноос буудлагын спортын гар бууны төрлөөр хичээллэж эхэлсэн бөгөөд 2009 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 4 алтан медаль хүртэж улсын аварга болсноор тамирчны гараагаа эхлүүлсэн. Түүнчлэн 2009 оны Зүүн Азийн наадамд Улсын дээд амжилтыг шинэчлэн тогтоож "Олон Улсын хэмжээний мастер" цол хүртсэн бол тус онд Катар Улсын Доха хотод зохиогдсон Хийн бууны Азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн.
ОУХМ ахлах ахлагч Э.Даваахүү нь Монгол Улсын буудлагын спортын эрэгтэй гар бууны төрөлд сүүлийн 10 жилд тэргүүлж байгаа бөгөөд 2012 оны Монголын бүх ард түмний спартакиадаас 2, 2016 оны Монголын бүх ард түмний спартакиадаас 3 алтан медаль, 2009-2019 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 30 алт, 3 мөнгөн медалийг тус тус хүртсэн.
2009 онд ОХУ-ын Новосибирск болон Эрхүү хотуудад зохиогдсон Олон улсын тэмцээнээс 5 алтан медаль хүртсэн. Мөн 2013 онд Солонгосын Чанвон, Германы Мюнхен хотод зохиогдсон Дэлхийн цомын тэмцээний шилдэг 8-д тус тус шалгарч байв.
2014 онд Оюутны Дэлхийн аварга



шалгаруулах тэмцээнээс хувийн 2 хүрэл, багийн 2 хүрэл медаль хүртэж Монгол Улсын дээд амжилтыг шинэчлэн тогтоосон. Мөн 2015 оны Оюутны Универсиад наадмаас багаараа мөнгө, хүрэл медаль, хийн гар бууны 10 метрийн дасгалд хувийн дүнгээр алтан медаль хүртэж, Универсиад наадмын түүхэнд Монгол Улсаас алт, мөнгө, хүрэл гэсэн гурван хүртсэн анхны тамирчин болсон.
2019 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Бээжин хотод зохиогдсон Дэлхийн цомын тэмцээнд 10 метрийн хийн гар бууны дасгалд 97 тамирчнаас 583 оноогоор 5 дугаар байрт жагсан финалд шалгарч "Токио 2020" Олимпын наадамд оролцох эрхээ авсан. Энэ амжилт нь Монголын буудлагын спортын түүхэн дэх эрэгтэй гар бууны тамирчдын Олимпын наадмын 2 дахь эрх юм. Мөн тус тэмцээний 25 метрийн олимпын хурдан буудлагын дасгалд Монгол Улсын дээд амжилтыг шинэчлэн тогтоосон.
Мөн 2020 оны 1 дүгээр сард Германы Мюнхен хотод зохиогдсон Дэлхийн цомын тэмцээнд 10 метрийн хийн гар бууны төрөлд амжилттай оролцож хүрэл медаль хүртжээ. ОУХМ Э.Даваахүү Монгол Улсын буудлагын спортын эрэгтэй гар бууны төрлийн дээд амжилтыг 20 гаруй удаа шинэчлэн тогтоож бүх дасгалын рекордыг эзэмшдэг тамирчин юм.

Эх сурвалж "Алдар" спорт хороо

БАЯРЛАЛАА ТАНДАА

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Ангийн "Орон сууцны алба"-ны нярав Ч.Гүндэгмаа ангийнхаа эмнэлгийн албанд дэмжлэг үзүүлж даралтын аппарат бэлэглээ. Түүний энэхүү тус нь хүнд хэцүү цагт бие биеэ ойлгон дэмжиж байгаагийн нэг илрэл нь юм.
Алба хаагчдынхаа эрүүл мэндэд үргэлж анхаарч ажилладаг Ч.Гүндэгмаад талархал дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал хамгийн сайн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөе.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ



ХОЛБООЧДОДОО ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл



Зэвсэгт хүчинд орчин цагийн цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан тус нэгтгэлд ажиллаж байсан ахмад холбоочин дайчдаа хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Арга хэмжээний үеэр холбоочин дайчдын төлөөлөл, дэд ахлагч Баасансүрэн, Мөнх-Эрдэнэ нар ая дууны мэндчилгээ дэвшүүлж, байлдагч Н.Өлзийнаран морин хуурын аялгуугаар мэндчилгээ дэвшүүлээ.
Хошууч Д.ДӨЛГӨРЖАВ

Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисуудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)